

Статистикийн хэлтсийн 5 дугаар сарын 04-нөөс 5 дугаар сарын 10-ны өдрийг хүртлэх 5 хоногт хийсэн ажлын товч мэдээ

2018.05.10

Өлгий хот

1. Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/323 дугаартай захирамжаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах орон тооны бус салбар зөвлөлд тус хэлтсийн даргыг оролцуулсан тул ҮАБЗөвлөлөөс ирсэн мэдээлэл, дүн шинжилгээний дарга н.Чулуунбатын хийсэн хуралд оролцов.
2. Аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын 04-р сарын тойм танилцуулгыг салбар тус бүрээр повер пойнтод оруулан файл хэлбэрээр бэлтгэв.
3. Мал төллөлт, төл бойжилт нь 2017 онтой харьцуулахад багассан, том малын зүй бус хорогдол ихэссэн тул энэ тухай тайлбарыг дэлгэрэнгүй бичиж ҮСХ-ны Хөдөө аж ахуйн салбар хариуцсан шинжээчид хүргүүлэв.
4. Хүнсний гол нэрийн барааны үнийн мэдээг цуглуулж, графикт хугацаанд төвд дамжуулсан.
5. Хэлтсийн портал сайтанд үнийн мэдээ болон 1-р улирлын инфографик мэдээлэл хийж байршуулав.
6. Судлаач нарын цуглуулсан “Өрхөд суурилсан нийгэм эдийн засгийн судалгаа”-ны 4 дүгээр сарын мэдээллийг нэг бүрчлэн хянаж, протокол хөтөлж, үндэсний хороонд хугацаанд нь явуулав
7. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Баян-Өлгий аймагт ажиллаж, аймгийн удирдлага, агентлаг, хэлтсийн удирдлагуудад болон ард иргэдэд уулзалт зохион байгуулахад хэлтсийн хамт олон идэвхтэй оролцов.
8. Аж ахуйн нэгж, байгууллагын 2016 оны тооллогын нэгдсэн үр дүнгийн тайлангийн тойм, график бэлтгэж танилцуулга ном гаргав.
9. Баян-Өлгий аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хамтран ажиллах тухай 01/714 тоот албан бичгийн хариуг хүргүүлэв.
10. Мэргэжлийн түр сургалтын чиглэлийн үйл ажиллагаатай холбоотой ААНБ-ын 2018 оны 1-р улирлын тодруулгын тайлбарыг ҮСХ-нд явуулсан.
11. 2017 оны “Баян-Өлгий аймгийн Ажил эрхлэлтийн байдал”-ын танилцуулгын тоо мэдээллүүдийг цуглуулан бэлтгэх ажлуудыг хийж байна.
12. Төвөөс ирүүлсэн улирлын, жилийн мэдээний тодруулгыг хугацаандаа хийж гүйцэтгэж дамжуулав.
13. ХАӨМС-ийн 4-р сарын мэдээллийг сумын төрийн сангийн төлөөлөгч нарт илгээсэн.

Статистикийн хэлтэс

